



INTERNATIONAL MONETARY FUND



Хэвлэлийн мэдээлэл No. 18/37
ШУУД ТҮГЭЭХ
2018 оны 2 дугаар сарын 6-ны өдөр

Олон Улсын Валютын Сан
АНУ-ын Вашингтон хот 20431

ОУВС Монгол Улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гурав дахь үнэлгээг дүгнэж, ажлын хэсгийн түвшинд тохиролцлоо

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэл нь гишүүн оронд ажилласан ОУВС-гийн мэргэжилтнүүдийн багийн урьдчилсан дүгнэлтийг танилцуулдаг. Энэхүү мэдээлэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд тус сангийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг илэрхийлэх албагүй юм. Ажлын хэсэг үнэлгээний урьдчилсан дүгнэлтэнд үндэслэн тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

- Монгол Улсын экспортлож буй гол түүхий эдийн эрэлт нэмэгдэж, эдийн засагт итгэх итгэл сайжирч байгаатай холбоотойгоор эдийн засаг сэргэж байна; макро эдийн засгийн гол зорилтот үзүүлэлтүүдийг, түүний дотор төсвийн алдагдал, гадаад валютын нөөцийн зорилтот түвшинг их хэмжээгээр давуулан биелүүллээ.
- Түүхий эдийн экспортын эрэлт цаашдаа муудаж болзошгүй, мөн газрын тосны үнэ өсч байгаа зэрэг нь томоохон эрсдэл болж байна. Иймд, эрх баригчид эрсдэлээс хамгаалах хөрөнгө нөөцөө үргэлжүүлэн бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг өндөр, тогтвортой түвшинд байлгахад шаардлагатай бүтцийн шинэчлэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ байна.
- Банкны системийг бэхжүүлэх, татварын боловсронгуй тогтолцоог бий болгох, төсвийн хяналтыг сайжруулах асуудалд ойрын хугацаанд анхаарлаа үргэлжүүлэн хандуулах нь зүйтэй.

Жэфф Готтлийбээр ахлуулсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн ажлын хэсэг 2018 оны 1-р сарын 24-нөөс 2-р сарын 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж, 2017 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гурав дахь үнэлгээний яриа хэлэлцээг хийлээ. Хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.3 сая ам. долларын зээл олгогдох юм ([Хэвлэлийн мэдээлэл № 17/193-ийг харна уу](#)).

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж, ноён Готтлийб дараах мэдэгдлийг гаргав. Үүнд:

“Түүхий эдийн экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэний үр дүнд эдийн засаг төсөөлж байснаас өндөр гүйцэтгэлтэй гарч байна. Эдийн засгийн өсөлт 2018 онд 5.0 хувь, 2019 онд 6.3 хувьд тус тус хүрэх тооцоо гарч байна. Засгийн газрын бодлогын тохиргооны хөтөлбөрийг ОУВС тэргүүтэй хандивлагчид 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтээр дэмжиж байгаа бөгөөд 2017, 2018 онуудад эргэн төлөгдөх хугацаатай байсан гадаад бондуудыг амжилттай дахин санхүүжүүлсэн, гадаад валютын нөөцийг 1.8 тэрбум ам.доллараар нэмэгдүүлсэн, засгийн газрын өр огцом багассан зэрэг нааштай үр дүнд хүрээд байна. Эдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нэлээд тогтворжиж, хүүгийн түвшин бууран засгийн газрын өрийн үйлчилгээний хуваарийг эрс сайжрууллаа. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлтөд хэд хэдэн эрсдэл байсаар байна. Тухайлбал, түүхий эдийн гадаад эрэлт буурах, газрын тосны үнэ нэмэгдэх зэрэг болно. Эдгээр эрсдэлүүд болон эрсдэлээс хамгаалах хөрөнгө нөөц хангалттай бүрдээгүйг харгалзан үзвэл төсөв, мөнгөний бодлогууд зохистой хэвээр байх шаардлагатай.

“Хөтөлбөрийн хүрээнд макро эдийн засгийн гүйцэтгэл эерэг байж, бүх үзүүлэлтүүд зорилтот түвшингээс хол давж биелсэн. Төсвийн үр дүнгийн гүйцэтгэл төсөөлж байснаас хамаагүй сайн гарсан нь орлогын төлөвлөгөө даван биелж, зарлага санхүүжилтийг хатуу хяналттай гаргасантай шууд холбоотой юм. 2017 оны гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт алдагдал ДНБ-ий 1.9 хувьтай тэнцсэн бөгөөд зорилтот түвшин 10.6 хувь, 2016 оны түвшин 17 хувь тус тус байсан билээ. Эрх баригчдын 2018 оны бодлогын хөтөлбөрийн хүрээнд төсвийн алдагдлыг үргэлжлүүлэн зохистой хэмжээнд барихын зэрэгцээ татварын шинэ хуулиудыг батлан хэрэгжүүлэх замаар татварын удирдлагыг бэхжүүлэн концесс, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагаанд тавих төсвийн хяналтыг боловсронгуй болгоно. Төсвийн гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давсан үр дүнтэй байгаа учраас Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тохирсон зарим бодлогыг нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх боломж бүрдэж байна. Тухайлбал, төрийн албан хаагчдын цалин хөлсийг сүүлийн хэдэн жил нэмээгүй байсныг эргэн харж, 2019 оноос нэмэхээр тусгалаа.

“Эрх баригчид банкны системийг бэхжүүлэх чиглэлээр хийж байгаа ажлуудаа үргэлжүүлж байгаа бөгөөд гол арга хэмжээнүүдийг төлөвлөгөө ёсоор авч хэрэгжүүлэх нь шийдвэрлэх үүрэгтэй юм. Хууль эрхзүйн чухал шинэчлэлүүд болох Банкны тухай болон Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиуд батлагдлаа. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ хэлэлцэж, удахгүй батлана. Үүнтэй зэрэгцээд банкны зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох ажлууд хийгдэж байна. Активын чанарын цогц үнэлгээний үр дүнг банк тус бүрт танилцуулсан байгаа бөгөөд банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ шаардлагатай тохиолдолд нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулах ажил ид явагдаж байна. Олон улсын шилдэг туршлагын дагуу төсвийн хөрөнгийг ямар

тохиолдолд банкиг дахин хөрөнгөжүүлэхэд ашиглаж болох, ашиглах шаардлагатай вэ гэсэн асуудлыг тодорхой зохицуулах Банкйг дахин хөрөнгөжүүлэх тухай хуулийн төслийг ойрын саруудад өргөн барьж батлах болно. Мөн түүнчлэн, эрх баригчид чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Ингэснээр банкуудын тайлан тэнцэл илүү хурдан сайжрах нөхцөл бололцоо бүрдэх юм.

“ОУВС-гийн ажлын хэсэг эрх баригчидтай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гурав дахь үнэлгээг дүгнэж, ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. Энэхүү тохиролцоог ОУВС-гийн Захирлуудын зөвлөл хэлэлцэж баталгаажуулна.

“Ажлын хэсгийг Монгол Улсад байх хугацаанд хамтран ажиллаж, бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлэн, зочлон хүндэтгэсэн эрх баригчдад талархал дэвшүүлье.”